



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 08

Номгон

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын төвийн айл өрхүүдийн хаус хорооллын орон сууцны барилгын зураг төсвийн үнийг ОНХС-с санхүүжүүлэхээр "ЦЭСДА" ХХК-тай 5.2 сая төгрөгийн гэрээ байгуулан зураг төсвийг 2017.07.27-д хүлээн авахаар урьдчилгаа 2.5 сая төгрөг олгосон ч гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй, зураг төсвийг хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.6 "бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих", 2017.06.25-ы өдрийн "Зураг төсөл боловсруулах талаар захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ"-ний 5-д "2017 оны 05 сарын 25-наас... 2017 оны 07 сарын 27 хүртэл 50 хоног дотор ажлыг зургийг хийх..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5-д заасан "... мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага нөхцлийг хангаагүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй "ЦЭСДА" ХХК-иар зураг төсвийг бүрэн гүйцэтгүүлж хүлээж авах.




2517121

2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын Засаг дарга Д.Батбаатар, Санхүүгийн албан дарга Д.Эрдэнэбулган, нягтлан бодогч Б.Үлэмжсонин нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

БИЧСЭН:
АУДИТОР  Ж.ӨСӨХБАЯР



ЗӨВШӨӨРСӨН:
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
 Д.БАТБААТАР
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА:
 Д.ЭРДЭНЭБУЛГАН
НЯГТЛАН БОДОГЧ:
 Б.ҮЛЭМЖСОНИН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 09

Номгон

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ИТХ-аас сангийн төсвийг баталж өгөөгүй байхад иргэн Б.Батцэнгэлтэй 12.0 сая төгрөгийн дүн бүхий "Эрх зүйн туслалцаа үзүүлэх" гэрээг ЗДТГ-ын дарга нь төсвийн захирагчийг төлөөлөн гэрээ байгуулж санхүүжилтийг олгосон ба иргэн Б.Батцэнгэл нь санхүүжилтээ бүрэн авсан ч гэрээний үүргээ биелүүлээгүй төсвийн үргүй зардал гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2016 оны 15 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.8 "Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, ... зориулан зарцуулна", 3.5.7 "сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг... ИТХ-аар батлуулах", гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-д "Өмч, хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусдад зүй бусаар ашиглуулсан,...", 4.1.5-д заасан "... мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага нөхцлийг

2517123

хангаагүй", 4.1.7-д "Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрхи зөрчлийг хууль хяналтын байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлэх.

1. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын Засаг дарга Д.Батбаатар, Санхүүгийн албан дарга Д.Эрдэнэбулган, Мал эмнэлэг, үржлийн дасгийн дарга Ж.Ёндонпил нарт хариуцуулав.


АУДИТОР  Ж.ӨСӨХБАЯР


БИЧСЭН:


17143544
ВНОА0067 9007423

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
 Д.БАТБААТАР

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА:
 Д.ЭРДЭНЭБУЛГАН

МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН
ТАСГИЙН ДАРГА:
 Ж.ЁНДОНПИЛ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 10

Номгон

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сум хөгжүүлэх сангаас олгосон 29 иргэний нийт 148.0 сая төгрөгийн үлдэгдэл бүхий зээлийн хувийн хэргийг 2017 оны 01 дүгээр сард үрэгдүүлсэн гэх шалтгаанаар зээлийн үлдэгдэлийг нотлох анхан шатны баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн газрын 2016 оны 15 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.8-д "Сумын Засаг дарга зээлдэгчийн талаар дараах баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгална" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1.Хувийн хэрэг алга болсон асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулж баримтыг бүрдүүлэх.
- 2.Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын Засаг

2517125

дарга Д.Батбаатар, Санхүүгийн албан дарга Д.Эрдэнэбулган, Мал эмнэлэг,
үржлийн дасгийн дарга Ж.Ёндонпил нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

БИЧСЭН:
АУДИТОР Ж.ӨСӨХБАЯР



ЗӨВШӨӨРСӨН:

БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.БАТБААТАР

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА:
Д.ЭРДЭНЭБУЛГАН

МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН
ТАСГИЙН ДАРГА:

Ж.ЁНДОНПИЛ

MC. E. J. P. L.

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 11

Номгон

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 23 иргэний 113983.5 мянган төгрөгийн зээлийн гэрээний хугацаа дуусч хугацаа хэтэрсэн байна.

2. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 6 иргэний 34115.0 мянган төгрөгийн зээлийг 2015 онд шүүхэд шилжүүлж Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2015 оны 12 дугаар төлүүлэх шүүгчийн захирамж гарсан ч тухайн зээлдэгч нараас зээлийн төлбөр төлөгдөөгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 15 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3.5.5-д " зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

3. Хугацаа хэтэрсэн зээлүүдийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, санд төвлөрүүлэх.

2517131

4. Шүүгчийн захирамж гарсан ч төлбөр төлөгдөөгүй зээлүүдийг албадан гүйцэтгүүлэх тухай шүүгчийн захирамж гаргуулж шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэх.

5. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 04 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын Засаг дарга Д.Батбаатар, Санхүүгийн албан дарга Д.Эрдэнэбулган, Мал эмнэлэг, үржлийн дасгийн дарга Ж.Ёндонпил нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

Бичсэн:
АУДИТОР  Ж.ӨСӨХБАЯР



6117143544
84040067 9007423

Зөвшөөрсөн:
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
 Д.БАТБААТАР
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА:
 Д.ЭРДЭНЭБУЛГАН
МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН
ТАСГИЙН ДАРГА:
 Ж.ЁНДОНПИЛ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 12

Номгон

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого, зарлага, зээл авсан 29 иргэний 148.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийн мэдээллийг журамд заасан хугацаанд аймгийн Засаг даргад хүргүүлээгүйгээс Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах нөхцлийг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.4-д " Сумын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг... аймгийн Засаг даргад хүргүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сангаас олгосон зээлүүдийн үлдэгдэл болон орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлж зээлдэгчдийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах нөхцлийн бүрдүүлэх.
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын Засаг

2517129

дарга Д.Батбаатар, Санхүүгийн албан дарга Д.Эрдэнэбулган, Мал эмнэлэг, үржлийн дасгийн дарга Ж.Ёндонпил нарт хариуцуулав.


АЛБАН ШААРДЛАГЫГ

БИЧСЭН:
АУДИТОР Ж.ӨСӨХБАЯР



ЗӨВШӨӨРСӨН:

БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.БАТБААТАР
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА:
Д.ЭРДЭНЭБУЛГАН
МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН
ТАСГИЙН ДАРГА:
Ж.ЁНДОНПИЛ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.